



2023 он 12 сар 13 өдөр

Дугаар 19/23

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн нарийн бичгийн даргын
үйл ажиллагааны журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 12 сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн “ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, гүйцэтгэлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх Захирал (Г.Цогбадрах)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор (П.Бямбасүрэн)-т тус тус даалгасугай.

ДАРГА



О.ОДБАЯР



АРД ДААТГАЛ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам /цаашид “журам” гэх/-аар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргын /цаашид “нарийн бичгийн дарга” гэх/ эрх, үүрэг түүний үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2 Компанийн нарийн бичгийн дарга нь тухайн компанийн засаглалын асуудлыг хариуцах үндсэн ажилтан байх ба үнэт цаас гаргагчийн тогтмол биелүүлэх үүргийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна. Нарийн бичгийн дарга нь компанийн удирдлагаас хараат бус байх бөгөөд дараах үндсэн үүргийг хүлээнэ.
 - 1.2.1 Компанийн засаглалын талаар бодлого боловсруулахад оролцох;
 - 1.2.2 Компанийн засаглалын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;
 - 1.2.3 Хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид “ХЭХ” гэх/, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулах, шаардлагатай материалуудыг бэлдэх;
 - 1.2.4 Компанийн мэдээлэл, харилцаа холбоо, олон нийтэд мэдээлэл хүргэх;
 - 1.2.5 Хувьцаа эзэмшигчээс ирсэн гомдол, хүсэлтийг хүлээн авч, тухайн асуудлыг шийдвэрлэхэд компанид туслах, компани доторх маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх;

Хоёр. ТУЗ-ийн Нарийн бичгийн даргыг томилох

- 2.1 Нарийн бичгийн даргыг компанийн ТУЗ-ийн даргын санал болгосноор нийт гишүүдийн олонхийн саналаар томилно. Нарийн бичгийн даргад нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна.
 - 2.1.1 Дээд боловсролтой;
 - 2.1.2 Нарийн бичгийн даргын үүрэг хариуцлагыг гүйцэтгэхэд шаардлагатай ажлын туршлагатай байх;
 - 2.1.3 Компанийн тухай хууль тогтоомжийн талаар мэдлэгтэй;
 - 2.1.4 Компанийн тухай хуулийн 75.8-д заасан шаардлагыг хангасан;
- 2.2 ТУЗ-ийн гишүүд нарийн бичгийн даргад нэр дэвшигчтэй холбоотой дараах мэдээллийг хүлээн авна.
 - 2.2.1 Боловсрол, өнгөрсөн жилд хашиж байсан ажлын туршлага;
 - 2.2.2 Компанид хувьцаа эзэмшдэг эсэх (хэрэв эзэмшдэг бол хувьцааны тоо хэмжээ);
 - 2.2.3 Компанийн эрх бүхий албан тушаалтан болон хувьцааны хяналтын багц;
 - 2.2.4 Нарийн бичгийн даргын албан тушаалыг хашихад ноцтой нөлөөлөхгүй талаар бусад мэдээлэл;
- 2.3 Нарийн бичгийн даргатай хийгдэх хөдөлмөрийн гэрээний нөхцөлүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталгаажуулах ба нөхцөлүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж тухайн гэрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурна.
- 2.4 ТУЗ-ийн дарга нь нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг томилно.
- 2.5 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь бүрэн эрхийн хугацаанд компанийн үндсэн ажилтан байна.

Гурав. ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын бүрэн эрх



3.1 Компанийн засаглалын бодлого, үйл ажиллагаа

- 3.1.1 Олон улсын хэмжээнд явагдаж буй компанийн засаглалын шинэтгэлийг судлах, ТУЗ болон удирдлагын багт шинэтгэлийн талаар мэдээлэл хүргүүлэх, зөвлөх, эдгээр шинэтгэлүүдийг компани дээр хэрэгжүүлэх арга боломжийг судлах;
- 3.1.2 Компанийн засаглалын бодлого болон үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах санал, засаглалыг сайжруулах төлөвлөгөө, журмын төсөл боловсруулж ТУЗ-дхүргүүлэх;
- 3.1.3 Компанийн дотоод бодлого, журмыг боловсруулахад компанийн гүйцэтгэх удирдлага болон бусад холбогдох албан тушаалтанд зөвлөх;
- 3.1.4 Шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүн болон компанийн бусад эрх бүхий албан тушаалтан, дотоод хяналтын ажилтанд компанийн засаглалын бодлого, журмыг танилцуулах;

3.2 Харилцаа холбоо, ил тод байдал

- 3.2.1 Компанийн хуульчтай хамтарч ажиллах, мэдээлэл солилцох;
- 3.2.2 Компанийн талаарх мэдээлэл, тайлангуудыг холбогдох дүрэм журмын дагуу төрийн эрх бүхий байгууллагад хүргэж байгаа эсэхд хяналт тавих;
- 3.2.3 Олон нийтэд ил болгох компанийн мэдээллийг хуульд заасан арга хэрэгслээр хүргэх асуудлыг хариуцах;
- 3.2.4 Хувьцаа эзэмшигч, зээл олгогчийн хүсэлтээр шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй хүргэх асуудлыг хариуцах;
- 3.2.5 Компанийн хувьцаа эзэмшигч, ТУЗ, түүний дэргэдэх хороод, гүйцэтгэх удирдлага, бусад салбар хэлтэс хороодын мэдээлэл солилцооны үр дүнтэй байдлыг хангахад хувь нэмэр оруулан ажиллах;
- 3.2.6 Компанийн нууц мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, эрх бүхий этгээдийг тухайн мэдээлэлд зохих ёсоор нэвтрүүлэхэд хяналт тавих
- 3.2.7 Компанийн засаглалын ажилтан буюу ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь өөрийн үүргийг гүйцэтгэхтэй холбоотойгоор компанийн бүх алба хэсэг ажилтнаас мэдээлэл авах эрхтэй.

3.3 Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулах.

- 3.3.1 ХЭХ болон ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулж явуулахдаа компанийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөх ба дараах үүргийг хүлээнэ.

- 3.3.1.1 ХЭХ-д оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг компанийн бүртгэлийг үндэслэн гаргаж ТУЗ-ийн даргад хүргүүлэх;

- 3.3.1.2 ТУЗ-ийн хурлын товыг ТУЗ-ийн даргатай хэлэлцэн гаргаж, ТУЗ-ийн гишүүдэд мэдэгдэх;


- 3.3.1.3 ТУЗ-ийн баталгаажуулсан жагсаалтын дагуу хуралд оролцох хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, бусад эрх бүхий этгээдэд хурлын зарыг хүргүүлэх;

- 3.3.1.4 Компанийн удирдлагын баг болон компанийн хөндлөнгийн аудит, зөвлөх байгууллага, дотоод хяналт шалгалтын газарт хурлын зарын талаар мэдээлэх;

- 3.3.1.5 ХЭХ-ын зарыг хуульд заасан арга, хэрэгслээр мэдээлж байгаа эсэхэд хяналт тавих;

- 3.3.1.6 ХЭХ-ын зарын хамт хурлаар хэлэлцэх асуудлууд түүнд холбогдох мэдээлэл, баримт бичгүүд, хурлаас гаргах шийдвэрийн төсөл, саналын хуудас зэргийг бэлтгэх, хуралд оролцогчид хурлын өмнө танилцах боломж, нөхцөлийг хангах;

- 3.3.1.7 Хувьцаа эзэмшигчдийн бөглөсөн саналын хуудсыг хураан авч тооллогын комисст шилжүүлэх ба зөвлөлийн гишүүдийн бөглөсөн саналын хуудсыг хураан авч зөвлөлийн даргад шилжүүлэх;



3.3.1.8 ХЭХ-ын тэмдэглэл хөтлөх ба баталгаажуулсан тэмдэглэл, шийдвэрийн хадгалалт, хамгаалалтыг хариуцах;

3.3.1.9 Хувьцаа эзэмшигчдэд (ТУЗ-ийн гишүүдэд) хурлын тэмдэглэл, шийдвэрийг танилцуулах, тэдгээрийн хүсэлтийн дагуу тэмдэглэлийн хувийг хүргүүлэх;

3.3.1.10 ХЭХ процесс, холбогдох дүрэм, журмын талаар зөвлөгөө өгөх, оролцогчдын асуултад хариулах;

3.3.1.11 ХЭХ-ыг хуралдуулах, удирдан явуулах явцад үүссэн маргаан, үл ойлголцлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авах.

3.4 Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт.

3.4.1 Компанийн хууль тогтоомжийг тухайн компани хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих;

3.4.2 Компанийн эрх бүхий албан тушаалтан болон бусад ажилтнаас компанийн засаглалын бодлого, дүрэм журмыг зөрчсөн тохиолдлыг ТУЗ-ийн даргад нэн даруй мэдэгдэх. Хэрэв ТУЗ-ийн дарга, гишүүд компанийн дүрэм журмыг зөрчвөл ХЭХ-ын хурал дээр зөрчлийг мэдэгдэх;

3.4.3 ТУЗ-д компанийн засаглалын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, анализ хийх болон сайжруулах зэрэгт дэмжлэг үзүүлэх;

3.4.4 Компанийн удирдлага ба хувьцаа эзэмшигчдийн хооронд болон хувьцаа эзэмшигчид хооронд үүссэн сонирхлын зөрчлийг шийдвэрлэхэд туслас, зуучлагчаар оролцох;

3.4.5 Компанийн бичиг баримтыг хадгалах, эрх бүхий албан тушаалтны шаардлагаар танилцуулах, хадгалах хугацаа нь дууссан баримт бичгийг архивт шилжүүлэх ажлыг хариуцахаас гадна хуулбарыг зохих этгээдэд хүсэлтийн дагуу гаргаж өгөх;

3.4.6 Компанийн хувьцаа эзэмшигчдээс ирсэн гомдол, саналыг хүлээн авч, бүртгэл хөтлөх, холбогдох газар, хэлтэс, ажилтанд хүлээлгэн өгч, хүлээн авсан этгээд уг гомдол, саналыг цаг хугацаанд нь барагдуулж, хариу өгч байгаа эсэхэд хяналт тавих;

3.4.7 Хувьцаа эзэмшигчийн эрх зөрчигдсөн асуудлыг бүртгэж, шалгалтын үр дүнг зөвлөлийн даргад мэдэгдэх;

3.4.8 Компанийн засаглалын кодекст заасан засаглалын зарчмуудын хэрэгжилтийг хууль, журамд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

3.4.9 Хувьцаат компанид холбогдолтой хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллах;

Дөрөв. ТУЗ-ийн Нарийн бичгийн даргыг чөлөөлөх

4.1 ТУЗ-ийн нарийн бичгийн даргын бүрэн эрхийн хугацаа нь ТУЗ-ийн шийдвэрээр чөлөөлөгдөх хүртэл байна.

4.2 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга дараах тохиолдолд ажлаас чөлөөлөгдөнө. Үүнд:

4.2.1 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

4.2.2 Хууль тогтоомжид заасан шаардлагыг хангахгүй болсон.

Тав. Бусад

5.1 Журмаар зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн Дүрэм болон холбогдох бусад дүрэм, журамд заасны дагуу зохицуулна.

5.2 Энэхүү журам нь Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор хүчин төгөлдөр болно.